



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 219

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Автотээврийн тухай хуулийн 17¹ дүгээр зүйлийн 17^{1.2} дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Шадар сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2018 оны 192 дугаар тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-д дараах нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

1.1. 1 дүгээр зүйлийн 1.3, 4 дүгээр зүйлийн 4.6-4.9, заалтуудыг бүхэлд нь, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2.3 заалтуудаас “лац” гэснийг, 7.2.2 заалтаас “лацны”, 7.3 заалтаас “лацыг” гэснийг тус тус хасах;

1.2. 4 дүгээр зүйлийн 4.3.1, 5 дугаар зүйлийн 5.6 заалтын “баталгаажуулсан” гэснийг “гэрчлүүлсэн” гэж өөрчлөх;

1.3. 2 дугаар зүйлийн 2.5 заалтыг “автотээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. 1-р хэсэг. Ерөнхий шаардлага. MNS 4410-1:2002¹ стандартад заасан улсын дугаарыг дараах автотээврийн хэрэгсэлд олгоно” гэж өөрчлөх;

1.4. 2 дугаар зүйлийн 2.5.1.2 дэх заалтын “хуулийн” гэсний дараа “3 дугаар зүйлийн” гэж нэмэх;

1.5. 2 дугаар зүйлийн “2.5.6. Автотээврийн хэрэгслийн гэрчилгээ нь “энгийн”, “эко”, “нийтийн зорчигч тээвэр”, “технологийн” гэх мэт улсын дугаарын дэвсгэр өнгийг бичих талбартай байна” гэж шинээр нэмэх;

1.6. 2 дугаар зүйлийн “2.5.7 автотээврийн хэрэгслийн гэрчилгээг монгол, англи хэл дээр хэвлэнэ”, гэж шинээр нэмэх;

1.7. 2 дугаар зүйлийн 2.6 дахь заалтыг “Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг дараах тохиолдолд сольж олгоно”, гэж өөрчлөх;

1.8. 2 дугаар зүйлийн “2.6.1 анх олгосон улсын бүртгэлийн дугаарыг орон нутгаас Улаанбаатар хот, Улаанбаатараас орон нутагт, нэг аймгаас нөгөө аймагт шилжих тохиолдолд тухайн орон нутгийн сери бүхий дугаараар сольж олгоно”, гэж шинээр нэмэх;

1.9. 2 дугаар зүйлийн “2.6.2. нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ашиглаж эхлэх болон хасагдах тохиолдолд автотээврийн хэрэгслийн улсын дугаарын сери

болон тоог өөрчлөхгүйгээр зөвхөн өнгийг өөрчлөн энгийн дугаараар сольж олгоно”, гэж шинээр нэмэх;

1.10. 3 дугаар зүйлийн “3.7. Бүртгэлийн байгууллага нь автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг нийтэд нээлттэй ил тод зохион байгуулна”, гэж шинээр нэмэх;

1.11. 3 дугаар зүйлийн “3.8. Бүртгэлийн үйл ажиллагаа явагдаж буй бүх салбар төвүүдэд дэлгэц байршуулан иргэн, хуулийн этгээд улсын бүртгэлийн дугаарыг сонгох боломжоор хангасан байна”, гэж шинээр нэмэх;

1.12. 3 дугаар зүйлийн “3.9. Бүртгэлийн байгууллага иргэд гар утаснаасаа болон бүртгэлийн байгууллагын цахим хуудаст хандаж улсын дугаар захиалах боломжийг бүрдүүлсэн байна”, гэж шинээр нэмэх;

1.13. 4 дүгээр зүйлийн 4.3.3 болон 5 дугаар зүйлийн 5.2.3 заалтыг “нотариатаар гэрчлүүлсэн гэрээ, хэлцэл / Монгол Улсын Иргэний хуульд заасан өмчлөх эрх шилжүүлэх бүх төрлийн гэрээ /”, гэж өөрчлөх;

1.14. 4 дүгээр зүйлийн 4.5 дахь заалтыг “Автотээврийн хэрэгсэлд “Автотээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. 1-р хэсэг: Ерөнхий шаардлага”. MNS 4410-1:2002¹ стандартын дагуу улсын дугаар олгоно”, гэж өөрчлөх;

1.15. 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалтын “өв залгамжлалын” гэснийг “өвлөх эрхийн” гэж өөрчлөх;

1.16. 5 дугаар зүйлийн “5.7 Өмчлөгч автотээврийн хэрэгслийг гэрээсэлсэн, гэрээслэлээ өөрчилсөн, цуцалсан бол энэ тухай Монголын нотариатчдын танхимын албан хүсэлтийг үндэслэн мэдээллийн санд бүртгэнэ”, гэж шинээр нэмэх;


1.17. 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг “Түр дугаарыг дараах тохиолдолд олгоно”, гэж өөрчлөх;

1.18. 9 дүгээр зүйлийн 9.2 заалтыг 9.1.1 гэж дугаарлалтыг өөрчлөн, “Монгол Улсад бүртгэлтэй автотээврийн хэрэгслийг экспортод гаргах хүртэлх хугацаанд “Автотээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. 1-р хэсэг: ерөнхий шаардлага”. MNS 4410-1:2002¹ стандартын D хавсралтын 4 дэх зурагт заасан загварын хүрээнд түр дугаарыг олгоно”, гэж өөрчлөн найруулах;

1.19. 9 дүгээр зүйлийн 9.3 заалтыг 9.1.2 гэж дугаарлалтыг өөрчлөн, “Автотээврийн хэрэгсэл худалдаалах албан ёсны эрх бүхий байгууллагын худалдан борлуулахаар импортоор оруулж ирсэн шинэ автотээврийн хэрэгсэлд гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэгт үндэслэн үзэсгэлэн худалдаанд оролцох, агуулах, хүрэх, техникийн хяналтын үзлэгт хамрагдах зорилгоор авто замын хөдөлгөөнд оролцох үед түр дугаар олгоно”, гэж өөрчлөн найруулах;

1.20. 9 дүгээр зүйлийн 9.4 дугаарлалтыг 9.2 гэж өөрчлөх;

1.21. 9 дүгээр зүйлийн 9.5 дугаарлалтыг 9.3 гэж өөрчлөн, “Автотээврийн хэрэгсэл худалдаалах албан ёсны эрх бүхий байгууллагын албан хүсэлт, гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг, улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн 9 дүгээр зүйлийн 9.1.2 -т заасан дугаарыг олгоно”, гэж найруулах;



1.22. 9 дүгээр зүйлд “Энэхүү журмын 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь хэсэгт заасан түр дугаарыг “Автотээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. 1-р хэсэг: ерөнхий шаардлага”. MNS 4410-1:2002¹ стандартын D хавсралтын 4 дэх зургийн “Transit” гэдгийн оронд албан ёсны борлуулагчийн нэр, “дугаарын оронд автотээврийн хэрэгслийн арлын дугаарыг бичиж олгоно”, гэж нэмэн 9.4 гэж дугаарлах;

1.23. 9 дүгээр зүйлд “Түр дугаарыг 210 граммаас доошгүй жинтэй цаасан дээр хэвлэн олгоно”, гэж нэмэн 9.5 гэж дугаарлах;

1.24. 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтыг “Мэдээллийн сан нь Иргэний бүртгэлийн, жолоочийн даатгалын, техникийн хяналтын үзлэгийн , гааль болон татварын, цагдаагийн байгууллагын, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний бүртгэлийн, хөдлөх хөрөнгийн мэдээллийн зэрэг сангуудтай энэхүү журмын 10.1-т заасан журмын хүрээнд холбогдон харилцан мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлсэн байна”, гэж өөрчлөн найруулах;

1.25. 11 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтыг “Улсын дугаарыг “Автотээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. 1-р хэсэг: Ерөнхий шаардлага”. MNS 4410-1:2002¹ стандартын үзүүлэлт шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэнэ”, гэж өөрчлөх;

1.26. 11 дүгээр зүйлийн 11.6 дахь заалтыг “Улсын дугаарын тэмдгийг тухайн үйлдвэрлэгч автотээврийн хэрэгсэлд байрлуулан бэхэлж мэдээллийн санд бүртгэнэ”, гэж өөрчлөх;

1.27. 11 дүгээр зүйлд “Бүртгэлийн байгууллага нь улсын дугаарын бэлдэц болон бэхэлгээний боолтыг улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэгчдийн захиалгын дагуу тухайн үеийн зах зээлийн ханшаар захиалан нийлүүлж зарцуулалтад нь хяналт тавина”, гэсэн заалт нэмж, 11.8 гэж дугаарлах;


1.28. 11 дүгээр зүйлд “Энэхүү журмын 11 дүгээр зүйлийн 11.8 дахь заалтыг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө”. гэсэн заалтыг нэмж, 11.9 гэж дугаарлах;


1.29. Журмын 2 дугаар хавсралтаар баталсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн маягт”-ыг шинэчлэх;

1.30. Журмын 4 дүгээр хавсралтаар баталсан “Автотээврийн хэрэгслийн гэрчилгээний загвар”-ыг шинэчлэх.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ /Б.Гүрсоронзон/, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Г.Гантулга/ нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т үүрэг болгосугай.

САИД  Б.ЭНХ-АМГАЛАН



Зам, тээврийн хөгжлийн сайдын
2019 оны 06 сарын 25 өдрийн 219
дугаар тушаалын нэгдүгээр хавиралт

Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн маягт

Техникийн тодорхойлолт

Гэрчилгээ №	
Улсын дугаар	
Марк	
Загвар	
модификаци	
Төрөл	
Ангилал	
Зориулалт	
Үйлдвэрлэсэн он	
Бүхээг №	

Арал №			
Хөдөлгүүр №			
Хөдөлгүүр V(с.с)			
Өнгө			
Жолооны хүрдний байрлал	баруун <input type="checkbox"/> зүүн <input type="checkbox"/>		
Хөдөлгүүрийн тэжээлийн эх үүсвэр			
Бензин	<input type="checkbox"/>	дизель	<input type="checkbox"/>
шахсан хий	<input type="checkbox"/>	шингэрүүлсэн хий	<input type="checkbox"/>
цахилгаан	<input type="checkbox"/>	цахилгаан-бензин	<input type="checkbox"/>
Хий-бензин	<input type="checkbox"/>	Хий-дизель	<input type="checkbox"/>
Устөрөгчийн	<input type="checkbox"/>	Бусад	<input type="checkbox"/>

Шилжүүлсэн:

Өмчлөгч	Ургийн овог	
	/Эцэг/эх/-ийн нэр/ Байгууллагын нэр	
	Нэр	
	Регистрийн дугаар	
	Хаяг	
	Холбоо барих утас	

Шилжүүлэн авсан:

Өмчлөгч	Ургийн овог	
	/Эцэг/эх/-ийн нэр/ Байгууллагын нэр	
	Нэр	
	Регистрийн дугаар	
	Хаяг	
	Холбоо барих утас	

Шилжүүлсэн:


Шилжүүлэн авсан:

Өмчлөгчийн
гарын үсэг.....

Өмчлөгчийн
гарын үсэг.....

.....он.....сар.....өдөр

Зам, тээврийн хөгжлийн сайдын
20 19 оны 08 сарын 25 өдрийн 219
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Автотээврийн хэрэгслийн гэрчилгээний загвар

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ Technical specifications		MGL	ГЭРЧИЛГЭЭ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА Certificate issuing authority
Улсын бүртгэлийн дугаар Registration plate number	Хөдөлгүүрийн дугаар Engine number		
Марк, загвар Make, model	Үйлдвэрлэсэн он Year of manufacture		
Ангилал, хөдөлгүүрийн багтаамж Category, engine displacement	Импортолсон огноо Date of Importation		Бүртгэлийн ажилтан Registration officer
Бүх жин Gross vehicle weight	Өнгө, Color		Тэмдэг Stamp
Даац, суудлын тоо Loading capacity, number of seats	Тэнхлэгийн тоо Axes		Гарын үсэг Signature
Төрөл Type	Улсын бүртгэлийн дугаарын өнгө Color registration plate number	Он..... сар..... өдөрYYYY.....MM.....DD
Зориулалт Vehicle designation	Өмчлөгч Owner		Тусгай тэмдэглэл additional note
VIN дугаар, VIN number		
Арлын дугаар, Chassis number	Хаяг Address	
Бүхээгийн дугаар, Cabin number		№ 00000000	

ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ TECHNICAL INSPECTION			MGL САНАМЖ	МОНГОЛ УЛС MONGOLIA
Он, Сар, Өдөр YYYY.MM.DD	Техникийн байдал Technical status	Гарын үсэг Тэмдэг signature Stamp	<p>АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ӨМЧЛӨГЧ ТА:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Шинээр автотээврийн хэрэгсэл өмчилж авсан бол 72 цагийн дотор; ❖ Ашиглалтаас хассан бол 1 сарын дотор; ❖ Нэр, хаяг, арлын болон хөдөлгүүрийн дугаар, өнгө өөрчлөгдсөн бол 7 хоногийн дотор тус тус бүртгүүлэх; ❖ Жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдах; ❖ Хуульд заасан хугацаанд албан татвараа төлөх; ❖ Тогтоосон хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамруулах үүрэгтэй 	<p>CERTIFICAT D'IMMATRICULATION DU VEHICULE</p> <p>АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ</p> <p>CERTIFICATE OF VEHICLE REGISTRATION</p>

Засвартай бол хүчингүй
Not valid if edited

№ 00000000

-----00000-----